

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

САЙНШАНД СУМЫН 1 ДҮГЭР БАГТ ТОГЛООМЫН ТАЛБАЙ БАЙГУУЛАХ АЖИЛ

Сайншанд сум

2024.06.03

А. Ажил гүйцэтгэх хугацааны график хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хучний тоог тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В. Үнийн саналд зураг төсвийн үнийг **1 800 000 / Нэг сая найман зуун мянга** / төгрөгөөр, захиалагчийн хяналтын зардлыг талбайн угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгийн 2%-иар, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тооцож тусгаж ирүүлнэ.

Г. Төсөв зохиохдоо Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 30 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, төхөн хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "ІҮ" 81-95-12-г мөрдлөг болгоно.

Д. Авто тээврийн зардлыг ЗТХС-ын 2022.08.22-ны өдрийн А/233 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.

Е. ЗТХС-ын 2017 оны 212 дугаар тушаалаар машин механизмын зардлыг тооцож ирүүлнэ.

Ё. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

Ж. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.

З. Газар шорооны ажлын хийж гүйцэтгэхийн өмнө геодези хэмжилтийн эрхтэй байгууллагаар шугам трассын дагуу улаан шугам тавиулж илд далд ажлын актыг баталгаажуулсаны дараа ажлын эхлүүлэх шаардлагатай. Улаан шугам тавиулах үед захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллийг байцуулна.

1. Газар шорооны ажил

Газар шороо болон суурийн ажлыг хийж гүйцэтгэхдээ БНБД 50-02-17г мөрдлөг болгон ажиллана. Талбайг бульдозероор тэгшлэн хийн тромбовкоор нягтуулна.

2. Сагсны талбайн ажил

Хөрсийг хайргаар нягтуулж дэвсгэр үе хийж сагсны талбайг БМ-200 б-10см дэвсгэр үе хийж гүйцэтгэнэ. Бетон болон төмөр бетон бүтэцтэй суурийн ажлыг хийж гүйцэтгэхдээ БНБД 52-01-10г мөрдлөг болгон ажиллана. Ажил гүйцэтгэх хугацаанд Барилга хот байгуулалтын сайдын 2017.11.30-ны 195 дугаар "Барилгын ажлын

аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам"-ыг баримтлан ажиллана. Талбайг өнгийн тосон будгаар гар аргаар сайн чанартай будна.

3. Сагсны талбайн төмөр торон хашааны ажил

Суурийн бетон цутгаж сагсны талбайн Зм өндөртэй төмөр шонтой төмөр торон хашаа, төмөр шонтой жижиг хаалга хийж гүйцэтгэнэ. Торон хашааны ажлыг хийж гүйцэтгэхдээ Ган бүтээц БНБД 53-03-22г мөрдлөгө болгон ажиллана.

4. Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт, гадна төмөр хашааны ажил

БМ100 бетон дэвсгэр үе хийж резинин хавтан бетон шаланд наана. Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага MNS 6751:2019 мөрдлөг болгон ажиллах. Турник болон хогийн сав байрлуулан төмөр хийцийн бэлдэц бэлтгэн тосон будгаар 2 удаа будна. 0.6м өндөртэй торон төмөр шонтой төмөр сараалжин хашаа, төмөр шонтой жижиг хаалга угсарна. Торон хашааны ажлыг хийж гүйцэтгэхдээ Ган бүтээц БНБД 53-03-22г мөрдлөгө болгон ажиллана. М100 бетон шугаман суурь цутган хүүхэд тоглох элсэн талбай хийнэ/б=35/

5. Тоглоом суурилуулах болон сүүдрэвч хийх ажил

Хүүхдийн 3 урсгалтай гулсуур, дүүжин даажин, хол хөлний савлуур, эргэдэг диск, дугуй, гар эргүүлэг угсарж байрлуулна. Гадна талбайд төмөр хөлтэй модон тавцантай сандал угсарна. Сагсны шит болон 2ш сүүдрэвч байрлуулна. Сүүдрэвчийг хийж гүйцэтгэхдээ БНБД 54-02-21 модон бүтээцийн норм дүрмийг баримтлана ажиллана. Сүүдрэвчийн дээр OSB хавтангаар нэлэнхүйд нь бүрж дээврийн уян шинглас хар цаасаар бүрнэ. Модон хийцийг өнгийн тосон будгаар гар аргаар сайн чанартай будна.

6. Гадна гэрэлтүүлэг хийх ажил

Гэрэлтүүлгийн шонгууд нь зэвэрдэггүй ган төмөр, салхины хэт ачаалал бусад байгалийн нэлөөллийг тэсвэрлэх чадвартай болохыг баталсан баримт сертифкаттай байна. MNS 6805:2019 стандартыг хангаж ажиллах. Гэрэлтүүлгийн шон болон самбар, бүх тусгаарлагч сууриудыг норм дүрмийн дагуу газардуулна. Гадна талбайн 1 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэг биш-г угсрах. Гэрэлтүүлгийн самбар угсран АВВБ 3*50+1*35мм² гэрэлтүүлгийн кабелийг шуудуунд сунгах. Оролтын болон шугамын автомат угсран хугацааны рел суурилуулна.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Талбайн угсралтын ажлыг батлагдсан төсөв, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.

4. Барилгын талбайд хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлагах шаардлагатай.
5. Талбайн угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
6. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.
7. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
8. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч тухайн ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
9. Ажил гүйцэтгэж дууссаны дараа шугамын трассын дагуу геодези хэмжилтийн байгууллагаар гүйцэтгэлийн зураг гаргуулж ГХБХБГ-ын кадастрын мэдээллийн санд бүртгүүлнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:


САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ЧУЛУУНЦЭЦЭГ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСГИУУЛСАН:

САЙНШАНД СУМЫН
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР



Б.ЭНХМАНЛАЙ